

НОМ ЗҮЙН ШҮҮМЖ

«МОНГОЛ ҮНДЭСТНИЙ ТОВЧ ТҮҮХ»**(Хөх хот, 1977) хэмээх номын тухай
(шүүмж)**

«Монгол үндэстний товч түүх» хэмээх энэ зохиолыг 1977 онд Өвөр Монголын өөртөө засах орны монгол хэл бичиг, түүх судлалын газраас өөртөө засах тус орныг тунхагласны 30 жилийн ойд зориулан хэвлэн гаргажээ. Өвөр Монголын түүхчид 7 бүлэг бүхий уг зохиолдоо нийт монголчуудын эрт, дундад болон шинэ түүхийн зангилаа асуудлуудыг нэлээд өргөн цар хүрээтэй авч үзэхийг оролдсон боловч маогийн жанжлах үзэл санаанд тулгуурлан гаргажээ.

Монголчуудын түүхийн зарим асуудлыг хятадын түүхчид хэрхэн гуйвуулж байгааг тодорхой хэдэн жишээгээр харуулбал:

Уг номонд: «Монголын элсэн манхан, өргөн уудам тал бол угаасаа манай орны хойд зүгийн үндэстний цөөнхүүдийн янз бүрийн үйл явдлыг тусгасан түүхийн талбар юм» гэснээс (зохиолын 2-р тал) үзэхэд Бээжингийн удирдлагын их гүрний жанжлах бодлогыг тусгаж илэрхийлсэн нь илт байна. Монголыг хэзээнээсээ хятадын нэг хэсэг байсан юм шиг дүрслэхийг оролдсон энэхүү нотолгоо нь түүхэн үнэнд бүхий л талаар харш зохиомол зүйл болохыг хүннү, сяньби, кидан зэрэг Монголын түүхийн бүх баримт тодорхой харуулж байгаа юм.

Эртний Монголын Хүннү гүрэн хүчирхэг мандсан цагтаа Төв Азийн хээр талын нүүдэлчдийг эрхшээлдээ оруулан захирч, үлэмж хүч нөлөө бүхий хятадын Хан улстай мөр зэрэгцэх их гүрнүүдийн нэг байсныг хуучин хятадын өөрийнх нь сударт ч гэсэн үгүйсгээгүй байдаг.

Хан улс МЭӨ 198 онд Хүннү гүрнийг өөртэйгээ эн сацуу их улс мөн гэж зөвшөөрөн хүлээж, Хүннүгийн шаньюй, Хан улсын хаан хоёр тусгай гэрээ байгуулж, хоёр улсын хилийг хятадын Цагаан хэрмээр зааглан албан ёсоор тогтоогоод Цагаан хэрмээс урагших нутгийг хятадын хаад, хойтохыг шаньюй захирах тухай хэлэлцэн тохиролцож байжээ. Энэ тухай Хан улсын хааны нэгэн айлтгалд бичсэн нь «Урт хотоос (Цагаан хэрмээс) хойш нум барьсан улс шаньюйн цаазыг дагасугай, урт хотоос дотогш дээл малгайн улсыг би захирсугай» гэж зөвшөөрөн хүлээж байжээ. Үүгээр ч барахгүй Хан улс жил бүр Шаньюйд алт, магнаг торго, тариа будаагаар алба барих үүрэгтэй байжээ. Ийнхүү Хан улс 50-иад жилийн турш хүннүд алба барьжээ. Хүннү нараас хятадтай худалдаа хийх гэсэн шаардлагыг мөн гэрээ ёсоор Хан улс хүлээн дагаж байв. Хүннү нар Дорнод Туркестанд ноёрхлоо тогтоож, хятад, өрнө дахиныг холбож байсан «торгоны их зам» хэмээх олон улсын худалдааны гол зам дээр хятадын Хан улстай амжилттай өрсөлдөж байлаа.

Цагаан хэрмийн доторхи суурьшмал хятад, гаднах хээр талын нүүдэлчид нь угаас тэс өөр маягийн амьдрал ахуйтай тус тусдаа өвөр-

мөц онцлогтой юм. Ийм ч учраас хээр талын нүүдэлчид «Хятадын умард мужид нутагладаг үндэстний цөөнх» хэзээ ч байгаагүй бөгөөд байхыг ч хүлцэн тэвчихгүй байв.

Хятадын түүхчид хятад төвийн уламжлалт үзлийн үүднээс өөрөөр хэлбэл, хятадын эзэн хаадын булаан эзлэх түрэмгий бодлогын үүднээс хятад ба нүүдэлчдийн харилцааг авч үзэхдээ, тэдний газар нутаг, удам угсаа нь Хятадын «харьяа» буюу Дундад улсын «салшгүй бүрэлдэхүүн хэсэг байсан» мэтээр түүхийг гуйвуулж байна. Үнэн хэрэг дээрээ нүүдэлчдийн гарал үүсэл, эдийн засаг, аж байдал, амин зуулга, ахуй төрх, хэл, соёл, зан заншил зэрэг нь хятадаас эрс ялгаатай бөгөөд хятадын «нэгдмэл гэр бүл» гэгчид нь багтаж байгаагүй болохыг түүх, угсаатны зүй, хүн судлалын бүх баримт батлаж байгаа юм.

Түүнчлэн мөн эртний Монголын Сяньби улсын Таньшихуай хаан хүннүгийн урьдах эзэмшил газрыг өвлөн захирч хятадын Хан улсын хил хязгаарыг түгшүүртэй байдалд оруулж байжээ. Хан улс МЭ 147—167 оны үед Сяньбийн эсрэг цэрэг мордуулаад амжилт олоогүй учир Таньшихуайг вангийн хэргэмээр шагнаж ургийн холбоог үндэслэсэн гэрээ байгуулахаар элч төлөөлөгчөө явуулсан боловч Таньшихуай үүнийг нь огт тоомсорлолгүй эрс татгалзжээ.¹ Сяньби улс биеэ даасан тийм хүчирхэг улс болоод байсан тухай Хан улсын сайд Цай Юй 178 онд айлтгасан бичигтээ өгүүлсэн нь: «Хүннү улс буруулан зайлнаас сяньби улс хүчирхэг болж, түүний хуучин газрыг эзлээд арван түмэн цэрэг байгуулжээ...зэвсэг хурц, морь хурдан улсаас нэн хэтэрчээ» гэсэн байдаг.

Хятад түүхчид бас Түрэг, Кидан зэрэг Төв Азийн монгол, түрэг угсаатны улс аймгуудыг цөмийг хятадын эзэнт гүрний харьяанд байж «алба өргөж» байсан мэт үзэж батлахыг оролдож байна. «Монгол үндэстий товч түүх»-ийн 1-р талд «Бүр эрт МЭ IV зуунд шивэй нар хятадын зүүн Вэй болон баруун Ци улсад элч төлөөлөгчдөө байнга явуулж төрийн эрх баригчидтай нь уулзаж нутгийн эрхэм үнэтэй зүйлээр алба барьдаг байжээ» гэжээ. Хөрш зэргэлдээ улс Хятадтай худалдаа хийж, элч төлөөлөгчөө явуулж байсныг алба өргөж харьяаллыг хүлээж байсан мэтээр хятад түүхчид тайлбарлаж, түүхийн үнэнийг гуйвуулж байна. Хэрэг дээрээ хятадтай хөрш зэргэлдээ оршиж байсан улс орнууд нь өөрийн элч төлөөлөгчөөр бэлэг сэлт хүргүүлэн эдийн засаг, улс төрийн харилцаа тогтоож улс орныхоо дотоод, гадаад байдлыг бэхжүүлэх биеэ даасан тусгаар тогтносон орны төрийн бодлого явуулж байсан байна.

Тухайлахад Түрэгийн Буман хаан улсаа байгуулсны дараа хөрш улстай найрамдлын харилцаа тогтоох, худалдаа хөгжүүлэх бодлого явуулж байжээ. Үүний нэг тод жишээ бол Алтайн уулын өвөр биед зах зээл нээж, баруун умард хятадын Вэй улсаас гурил, будаа, бөс бараа, амттан, үнэртэн зэрэг зүйлийг авч зэр зэвсэг, мал, ангийн үс гарган худалдаж байсан ба хилийн орчим Түрэг улсыг төлөөлөн суух түшмэдийн газрыг байгуулж байсан явдал юм.

572 онд Тобо хаан ширээнд сууснаар Түрэг улс улам бэхжин хятадаас их алба авдаг болжээ гэж Тан улсын түүхийн шастирт тэм-

¹ Дальний восток и соседние территории в средние века. Сибирское отделение. 1980, с 72.

дэглэсэн байна.² VII зууны үеийн Түрэгийн хаант улсын тухай хятадын түүхийн зохиолд дурдахдаа «умард зүгийн нүүдэлчид ийм их хүчирхэг ер байгаагүй» гэж тэмдэглэсэн байна. Иймд элсэн цөлөөс хойших нүүдэлчин аймгууд хэзээ ч хятадын умард нутагт нутагладаг үндэсний цөөнх байгаагүй байна.

Кидан нар монгол нутагт байсан дээрх нүүдэлчин аймаг улсуудын нэгэн адил хөрш зэргэлдээ орших хятадын харьяанд ороогүйгээр барахгүй умард хятадыг эзэлж Ляо улс хэмээх хүчирхэг гүрнийг тэрлэн байгуулж байжээ. 1004 онд Хятадын Сун улсын хаан нь Киданд жил бүр 100000 лан мөнгө, 20000 толгой бөс бараагаар алба барихыг хүсч байжээ. Омог бардам Хятад улс Кидантай эрх тэгш харилцаа тогтоосонд киданчууд бардам байдаг байжээ.³ Дээр дурьдсан баримтууд нь Төв Азийн нүүдэлчид ямагт Хятадын харьяанд байв гэсэн хятад түүхчдийн үзэл бодлыг үндэс суурьтай няцааж байгаа юм.

Өвөр Монголд хэвлэсэн Монгол угсаатнуудын түүхийн зохиолд хятад түүхчид Монгол зэрэг нүүдэлчдийн түүхийг хятадын түүхийн нэгэн хэсэг мэтээр завхруулсан санаа зүйлийг тийнхүү шургалуулан байгаа нь хятад төвийн дээрэнгүй үзлийг баримталсаар ирсэн хятадын эрх баригчдын жанжлах бодлогын шууд үр дагавар мөн гэвэл зохино.

Ц. Гэрэл

² Н.Я. Бичурин. Собрание сведений о народах обитавших в Средней Азии в древние времена. т. I. М—Л. 1950. с. 233.

³ В. П. Васильев. «История и древности Восточной части Средней Азии от X до XIII в., с прил. пер. кит. известий о киданях, чжурчженях и монголо-татарах. ТВОРАО. СПб., 1857, с. 24.